



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/298

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 03/02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.5.1.4, “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.5.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 19,378,200 (арван есөн сая гурван зуун далан найман мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 11207 дугаар захирамжийн хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН ТӨСӨВ**

Д/д	Гүйцэтгэх ажил, арга хэмжээний чиглэл	Төсөв (мян.төг)
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэгдсэн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, боловсролын байдлын судалгаа хийж, цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, Өвөрхангай аймаг дахь Политехник коллежтэй хамтран ажиллах	-
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийг сурталчлах, олдмол хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээл ба хүртээмж хандлагын талаар подкаст бэлтгэх, түгээх	800,000
3	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах, хуулийн хэрэгжилтийн улсын үзлэг зохион байгуулах (Ээлтэй ажлын байрны болзолт нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах)	2,080,500
4	Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хүргэх, сургалт зөвлөгөө мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Олдмол хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	1,250,000
5	Хөгжлийн бэрхшээлийн талаар (Хамтдаа оролцож, хамтдаа шийдвэрлэе) нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгуулах	3,087,500
6	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисстой хамтран сумдад ажиллах	1,163,200
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүний автомашины зогсоолыг явган хүний зам, талбайн төлөвлөлт, техникийн шаардлага MNS 6808:2019 стандартад нийцүүлэн бий болгох, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах	2,497,000
8	Барилга байгууламжийн зураг төсөлд урьдчилан хяналт хийх үед хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангуулах, норм дүрмийг баримтлах, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг томилохдоо тулгуур эрхтний болон, харааны бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулах	-
9	Орон нутгийн онцлогт тохируулан үйлчилгээний хүртээмжийн шийдлүүдийг нэвтрүүлэх, шинэ санал санаачилга нэвтрүүлэх, "Тусламжийн хонх"-ыг сүлжээ дэлгүүр, эмийн сан, кинотеатр, Хөгжимт драмын театр, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв, ерхийн эрүүл мэндийн төвүүдэд байршуулах	750,000
10	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх	-
11	Төрийн байгууллагад дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг нэвтрүүлэх	1,500,000
12	Цаасан уутны үйлдвэрийг ажиллуулах	-

13	Хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авалтаар дэмжин ажиллах	-
14	"Сайн туслах" жишиг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих	4,250,000
15	Өвөрхангай аймаг дахь БЭСТ массаж төвийн бариач нарын үйл ажиллагааг дэмжин ажиллах, сурталчлах	
16	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын байр, хүртээмтэй орчин бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх	2,000,000
17	Олон улсын тэмдэглэлт өдрүүдийг төрийн бус байгууллагуудын оролцоотой зохион байгуулах	-
нийт		19,378,200

-оОо-